



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/292

Эрдэнэт

Г Тамирчдад дэмжлэг үзүүлэх тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 06 дугаар сарын 15-наас 18-ны өдрүүдэд Тайвань улсын Тайчун хотноо зохион байгуулагдах чөлөөт бөхийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд Орхон аймгаа төлөөлөн оролцох тамирчин М.Цогтгэрэл, Б.Халиунаа, Б.Идэрсайхан нарт 2000000 төгрөгийн, 2017 оны 06 дугаар сарын 29-нөөс 07 дугаар сарын 04-ний өдрүүдэд Америкийн Нэгдсэн улсад зохион байгуулагдах шатрын Дэлхийн нээлттэй тэмцээнд Орхон аймгаа төлөөлөн оролцох тамирчин Б.Янжинлхамд 500000 төгрөгийн, Улаанбаатар хотноо 2017 оны 06 дугаар сарын 02-ноос 04-ний өдрүүдэд зохион байгуулагдах “Ахмад-2017” спортын 3 дугаар наадамд оролцох С.Энхбаатар ахлагчтай баг тамирчдад 1000000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 3500000 /Гурван сая таван зуун мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын “Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ